

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 03 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар хуралдааныг 10 цаг 30 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 84.6 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин аймгийнхаа нутаг дэвсгэрт 20.0 сая мод шинээр тарих менежментийн болон гүйцэтгэх үйл ажиллагааны төсөл, арга хэмжээг нэгтгэсэн дэд хөтөлбөр	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Аймаг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн учраас ямар төрлийн мод тарих, аль суманд хэдэн мод тарих асуудлыг шийдвэрлэх үүднээс 1-2 жилдээ ургах боломжтой, тарьж сурсан улиас, бургас, хайлаас, шар хуайс, буйлаас, голт бор зэрэг ургах боломжтой мод тариалах, 2024 он гэхэд 2.0 сая мод тарих үрсэлгээтэй болох;</p> <p>2. Булган, Буянт зэрэг модны үрсэлгээ, харандаа бэлтгэх боломжтой сумдын судалгаа гарган, мэргэжлийн багаас бүрдсэн 3-4 ажлын хэсэг байгуулж, 02 дугаар сарын 15-наас сумдад ажиллах ажлыг зохион байгуулах;</p> <p>3. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Тэрбум мод тарьж, ургуулахын төлөө үндэстнээрээ нэгдье” аяны хүрээнд 20.0 сая мод тарих аймгийн зөвлөгөөн”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулахыг тус тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Л.Батбаяр, Сум дундын ойн ангийн дарга Ц.Даваахүү, нарт үүрэг болгов.</p>
2	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийн тайлан хэлэлцэх тухай	<p>ШИЙДВЭРЛЭСЭН нь:</p> <p>1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийн тайланг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, www.khutulbur.iaac.mn Авлигатай тэмцэх газрын цахим санд оруулан баталгаажуулж, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлэхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Ариунбилэг, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат нарт үүрэг болгов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР